

1913 ОНЫ МОНГОЛ-ТӨВДИЙН НАЙРАМДЛЫН ГЭРЭЭ

Ж. Баттөр*

Төвд орон (XIX-XX зуун зааг дээр)

Ө нөөгийн монголчуудын “Төвд, Түвд, Түвэд” зэрэг янз бүрээр бичдэг, монгол бичгээр “Төбэд” хэмээн бичдэг төвдчүүд өөрсдийгөө “Бөд” гэх ба Лхас аялгаар “Пө буюу По” гэнэ. Зарим номонд төвдүүд өөрсдийгөө “Пёба” гэдэг хэмээсэн буй. Харин эдүгээ энэ орныг өөрийн улсын нэг хэсгээ болгосон хятадууд “Шизан”, “Занчү” гэхчилэн нэрлэдэг. 4900 метрийн өндөрлөгт байрлах тул “Дэлхийн дээвэр” ч гэж нэрлэх нь бий.

Өнөөдөр БНХАУ-ын зүгээс өгсөн албан ёсны нэр нь “Tibet Autonomous Region” билээ. Тэгвэл монголчууд яагаад “Төвд” гэж нэрлэх болсон бэ гэсэн асуулт гарч ирж байна. Тэгвэл энэ үгийн учгийг түрэг хэлнээс гаргадаг. Учир нь түрэг хэлээр Төвдийг “Төбэн” гэж нэрлэх ба энэ үг нь олон тоон дээр “Төбэд” болдог. Төбэд нь түрэгээр heights буюу “өндөрлөг, уулс, нуруу” гэсэн утгатай ажээ.¹ Мөн зарим судлаачид Төвд гэдэг үг бол баруун Төвдийн өндөрлөг нутгийн хүмүүсийг нэрлэсэн “Тө-Пө” буюу “Дээд Пө” хэмээх үгнээс гаралтай гэж тайлбарласан буй.²

Төвд гэдэг нэр хамгийн эрт дурдагдсан сурвалж бол МЭ 590 оны үеийн Арабын Иштахригийн бүтээл гэнэ.³ Төвдүүдийн тухай Птолемейн эртний газар зүйн бүтээлд “Батай” гэсэн нэрээр гардаг бол Хятадууд Мин улсын үеэс “Занг” хэмээн дууддаг байжээ. Төвдүүдийн гарал үүслийн тухайд эрдэмтдийн нэг хэсэг нь зүүн хойд талаас нүүж очсон гэж, харин нэг хэсэг нь баруун өмнөд Ассам, Бирмээс очсон гэж хоёр янзын таамаглал дэвшүүлдэг бөгөөд төвд хэл нь “Бирм хэлний бүлэг”-т багтдаг. Зарим хэлзүйчид төвд хэлийг бирм, сикким, бангладеш, балба, бутан хэлнүүдтэй нэг бүлэгт оруулсан байдаг.

Төвдүүд эртнээсээ худалдаа наймаанд гаргуун улс агаад худалдааны гурван гол замтай байлаа. Тэдгээр худалдааны зам нь гэвэл өмнө зүгт Энэтхэг рүү, дорно зүгт Хятад руу, хойд зүгт Монгол руу чиглэнэ. Дээрх гурван замаар дээрх гурван орны худалдаачид Төвдөд очин худалдаа наймаа хийдэг байлаа. Харин Монголоос мөргөлчид хамаг л өнгөтэй, өөдтэй үнэтэй эд зүйлсээ зөөн Төвдийн сүм хийдүүдэд өргөл барьц болгон өргөдөг байжээ. Монголчууд жилд зун болон өвөл хоёронтоо Төвд рүү томоохон аян жин хийдэг байсан гэх бөгөөд энд тэндээс гарсан мөргөлчид, жинчид, лам нар, худалдаачид Монгол, Төвд,

* МУИС, ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

Хятадын хил болж байсан Хөх нуурт цуглан нийлж нэг том цуваа болоод Лхас руу хөдөлдөг байжээ. Ихэвчлэн найман сард болон нэг сард тийш хүрч очдог байж. Ингэж олуулаа нийлж хөдөлдгийн учир нь зам тоссон дээрэмчид, тонуулчдаас амь бие, эд малаа хамгаалах арга нь байж. Олон зуун жил ийнхүү зорчих зуур Монголд Төвдөөс гаралтай сарлаг, төвд банхар гэх мэт гэрийн тэжээмэл амьтад нутагшсан төдийгүй цаашлаад монгол хэлнээ Төвдийн үй олон үгс орж, хоол унд, хувцас хунар, эм тан, цан бүжиг гээд иргэний болоод шашны ихээхэн зүйлс шингэсэн билээ.

Монголын түүх бичлэгт XIX-XX зууны Монголын дотоод гадаад байдлын талаар нэлээд ул суурьтай судалсан. Харин 1913 оны Монгол Төвдийн гэрээг судлахад XIX-XX зууны зааг дээрх Төвдийн дотоод гадаад байдлын талаар товч атугай нягтлах хэрэгтэй юм. Ингэснээр уг гэрээг байгуулах нийгмийн болон улс төрийн цаад мөн чанарыг илрүүлж чадах болно. XIX зууны сүүлийн 25 жилд Төвд улс Англи, Манж Чин болон Орос гэсэн гурван орны ашиг сонирхлын зөрчилдөөний нэгэн төв болов. Энэ үед Монгол орон Манжийн колони болж хүч чадвар нь ихээхэн доройтсон байсан тул монголчуудын хувьд Манж Чин улсын ноёрхлоос гарах нь нэн тэргүүний зорилго нь байсан нь ойлгомжтой.

Манж Чин улс хил залгаа орнуудын газар нутаг, хүн амыг байлдан дагуулж эрхшээлдээ оруулах аян дайныхаа хүрээнд 18-р зууны эхнээс Төвд рүү залхаан цээрлүүлэх цэрэг илгээж эхэлсэн байна. Ялангуяа 1727, 1728, 1750 онуудад манж Чингийн эсрэг өрнөсөн төвдчүүдийн эсэргүүцлийг харгис хэрцгийгээр нухчин дарав. Чин улс Төвдийг дан ганц цэрэг зэвсгийн хүчээр эрхэндээ оруулсангүй. Төвдийн шашны дотоодын зөрчлийг дэвэргэж, янз бүрийн урсгалуудыг хагаралдуулж байлаа. Ийм арга замуудаар байр сууриа бэхжүүлсээр 1792 онд Төвд орон Манж Чин улсын ноёрхол дор орсон юм. Монголд суулгасан шиг Төвдөд Манжийн амбан сууж Далай ламын засаглалыг хянах болов. Түүнчлэн Манж-Хятадын цэргүүдийг Төвд даяар хуарагнуулан суулгав. Харин Төвдийн дотоодод Далай ламын засаглал нэр хүндтэй байжээ. Чин улс сулрахын хэрээр Далай ламын байр суурь, нөлөө улам бүр бэхжих болов.

XIX зууны эцсээр Англи улс Хималайн нурууны газар нутгийг булаан эзлэхээр өргөжин тэлэх бодлого явуулж эхэлсэн юм. Ингээд Английн цэргүүд 1865 онд Хималайн зүүн хэсэгт орших жижигхэн вант улс Бутан руу халдан оров. Бутанчууд нэлээд хэдэн сар эсэргүүцсэн ч эцэстээ хүчинд автан ялагдаж, нутгийнхаа өмнөд хэсгээс Англичуудад алдав. Мөн Төвд, Бутан, Энэтхэг, Балба (Nepal) улсуудтай хиллэдэг Сиккимд ч гэсэн Англи улс ийм маягаар нөлөөгөө тогтоов. Удалгүй Англи-Сиккимийн гэрээг байгуулсан ба уг гэрээнд Сикким улс Английн зөвшөөрөлгүй өөрийн газар нутгаас гуравдагч оронд өгч үл болно гэсэн заалт оржээ. Англичууд Төвд рүү энхийн арга замаар нэвтрэхийг эрмэлзэж байв. Учир нь нэгд, Төвдүүд Англид сайн дураар дагаар орохгүй нь лав байсан бөгөөд хоёрт, Манж Чин улс Төвд дэх өөрийн нөлөө ноёрхлоос яавч ухарч, буулт хийхгүй нь ойлгомжтой байлаа. Энэ үед Чин улсын газар нутаг дээр Английн консулын газрын түшмэл алагдсанаар Чин улс дахь Британий элч Т. Уэйд болон Чин улсын Цунли яамны тэргүүн Ли хунжан нар Чифу хотод хэлэлцээ хийж энэ нь гадаадынхан ялангуяа англичуудыг Чин улсад нэвтрэхэд ихээхэн түлхэц болов.

Уг хэлэлцээрт манж Чингийн газар нутаг дээр гадаадын дипломатуудыг хамгаалах, ялангуяа олон улсын дипломат ёс журмыг нэвтрүүлнэ гэж заав.⁴ Уг хэлэлцээрээр Англи улс Лхаст Төлөөлөгчийн газраа (Миссия) байгуулах эрхтэй болжээ. Харин төвдүүд Английн Төлөөлөгчийн газраа байгуулах эрмэлзлэлийг эсэргүүцэж байлаа. Чонду (Төвдийн Төлөөлөгчдийн Зөвлөлдөх байгууллага) Чин улсын эзэн хааны гаргасан энэ шийдвэрийг буруу зүйл хийлээ гэж үзэж байв. Ер нь европчууд Төвдөд анх 1661 онд очсон гэж үздэг байна. Анх хөл тавьсан хүмүүс бол Изеут шүтлэгтэн Австри гаралт Иохан Груебер, Бельги гаралт Алберт де Орвилле нар байжээ. Тэд Далай лам лугаа нүүр тулан уулзаж байв.⁵

Английн зүгээс Бенгалийн захирагч Варрен Хастингс 1774 онд East India Company-ийн харъяаны залуу зохиолч Жорж Боглег Бенгал, Төвд, Бутаны харилцааг, ялангуяа худалдааны харилцаа сайжруулахаар илгээж байв. Тэрбээр Төвдөд очиж Төвдийн засгийн газар дахь нөлөө бүхий тушаалтан Даш ламтай ихээхэн найрсаг харилцаатай болж байв. Түүнээс хойш ч Энэтхэг дэх Английн дипломатууд хэдэнтээ Төвдөд очиж байсан ажээ. Заримыг нь төвдүүд сэжиглэн нутагтаа оруулалгүй буцаадаг байв. 1888 онд Английн генерал Грахамын командалсан цэргүүд Төвдийн хилийн бэхлэлт рүү довтолж төвдүүдийг буу зэвсгээр далайлган Чумби хөндий рүү ухраан хөөсөн аж. Гэвч нэг их гүнзгий цөмрөлгүй Чин улстай мөргөлдөхөөс зайлсхийн цэргээ татжээ.

Удалгүй Манжийн амбан Энэтхэгт очиж Англичуудтай хэлэлцээийн ширээнд суув. Ингээд 1890 онд Англи-Чин улсын гэрээ байгуулагдав. Уг гэрээгээр Сикким дэх Британий протекторатыг Чин улс хүлээн зөвшөөрч, Төвд-Сиккимийн хилийг Тееста голоор тогтоосон байна. 1893 онд Худалдааны гэрээ байгуулагдаж, Төвдийн хилээс дотогш худалдаа хийх үүдийг нээв. Гэтэл гэрээг хэрэгжүүлэх болоход гэрээг үзэглээгүй төвдүүд уг гэрээг зөвшөөрөхгүй гэж мэдэгджээ.

Англи улс Төвд рүү нэвтрэх оролдлого хийх тусам төвдүүд Орос руу хандах болов. Төвдийг Орос руу хандахад ихээхэн хүчин чармайлт гаргаж байсан хүн бол буриад хамба Агваан Доржиев юм. Тэрбээр Далай ламын багш нарын нэг байлаа. Түүнчлэн Далай ламын шадруудын нэг, ерөнхий сайд Шатра нь Төвдийн Оросын талыг барьсан бодлогод тусалж байлаа. Ингээд Агваан Доржиев Далай ламыг Оросын Цагаан хаантай уулзуулах төлөөлөгчдийг ахлан Орост очжээ. Гэхдээ Төвд болон Орос улс ямар нэг байдлаар ойртлоо ч хоёр орны хоорондын зай хэтэрхий хол учир бодит байдал дээр харилцаагаа хөгжүүлэх нь ихээхэн төвөгтэй, бараг бүтэхгүй зүйл болох нь харагдсан байна. Үүнийг ч Оросын тал ойлгож байлаа.

1903 оны 1 сард Лорд Курзон Төвдтэй худалдаа болон бусад олон асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, Лхаст Английн Байнгын Төлөөлөгчийн газар байгуулахаар цэргээр хамгаалуулсан Английн Mission-г Лхас руу илгээв. Гэтэл гурван сарын дараа Оросын Засгийн газар Английн Гадаад Явдлын сайд Лорд Лансдоуне-д албан тодруулга бүхий бичиг гардуулав. Тэр бичигт: Орост Төвдийн талаар байгуулсан ямар нэг гэрээ байхгүй, Төвдтэй ч, Хятадтай ч, мөн бусад оронтой ч иймэрхүү гэрээ байгуулаагүй, тус оронд Оросын ямар нэг төлөөлөгч ч байхгүй бөгөөд Төлөөлөгчийн газраа байгуулах төлөвлөгөө ч байхгүй гэсэн байр сууриа илэрхийлжээ.

Ийнхүү Төвд Английн харилцаа хурцдав. Дээр нь Орос улс Төвдөд туслахгүй нь тодорхой боллоо. 1904 оны хавар Янгхасбэндийн командалсан англи энэтхэг цэрэг Төвд рүү халдан довтолж довтолгоогоо ширүүсүүлсээр Лхас

руу цөмрөн орсон байна. Энэ үед Далай лам Агваан Доржиевийн тусламжтайгаар Лхасыг орхин Монгол руу дутаав.

Ингээд 1904 оны 9 сарын 7-нд Лхаст Британи-Төвдийн гэрээ байгуулагдав. Уг гэрээг манжийн амбан болон Непалын төлөөгчид гэх мэт дипломатууд давхар батламжлав.

Уг гэрээний гол гол заалтыг дурдвал:

1. “Төвдийн Гянцуж болон Гартог, баруун Төвдийн Гаргүсад худалдааны газар нээнэ.
2. Төвдийн тал Энэтхэг рүү хийх болон Энэтхэгээс орж ирэх худалдааны бүх татварыг арилгана.
3. Төвдийн Засгийн газар дайны нөхөн төлбөрт хагас сая фунт стерлингийг Англид төлнө. Уг төлбөрийг төлж барагдуултал Чумби хөндий Английн мэдэлд үлдэнэ.
4. Английн зөвшөөрөлгүйгээр Төвдийн газар нутгаас ямар ч гүрэнд тасалж өгөхгүй, түрээслэхгүй. Төвдийн төсөв хөрөнгийг ямар ч гүрэн нэхэхгүй. Ямар ч гүрэн Төвдийн хэрэг явдалд хөндлөнгөөс оролцохгүй, Төвд рүү агентуудаа илгээхгүй.”

Гэтэл Чин улс Төвд дэх нөлөө нь суларч эхэлж буйд түгшиж, нөлөөгөө бэхжүүлэх бодлого явуулав. Юуны түрүүнд 1906 онд Англитай хэлэлцээр хийж эхлэв. Эл гэрээгээр тэд Төвд дэх өөрийн байр суурийг бэхжүүлж чадсан байна. Эл гэрээг байгуулахдаа Төвдийн засгийн газартай огтхон ч зөвлөлдсөнгүй. Уг гэрээнд зөвхөн Чин гүрэн л Төвдөд гол эрхтэй гэж заажээ. Энэ гэрээгээ ашиглаад Чин улс Төвдийн засаг захиргааны ажилд хутгалдан оролцож, нөлөөгөө улам бүр ихэсгэж чадсан байна.

1907 онд Англи, Орос улсууд Ази дахь сонирхол, нөлөөний хүрээгээ тодорхой болгох, тулгамдсан асуудлуудаа зохицуулах зорилгоор хэлэлцээр хийж эхлэв. Улмаар тодорхой тохиролцоонд хүрч, гэрээ байгуулжээ. Уг гэрээ нь Перс, Афганистан, Төвдийн асуудлуудыг хамарсан байна. Гэрээний Төвдийн талаарх заалтуудыг үзвэл:

Төвдийн гадаад харилцаан дахь стаус квог хадгалах Их Британий онцгой сонирхлыг хүлээн зөвшөөрч:

1. Төвдийн дотоод засаг захиргаанд хөндлөнгөөс оролцохыг зайлсхийх,
2. Лхасын гэрээнээс үүдээгүй асуудлаас бусдаар Төвдтэй хэлэлцээ хийхдээ Чин улсаар зуучлуулан оролцоно.
3. Лхас руу төлөөлөгчид илгээхгүй байх,
4. Зам, уул уурхайн концесс эрэлхийлэхгүй, авахгүй.
5. Төвдийн сан хөмрөгийн ямар нэг хэсгийг авч ашиглахгүй байх

гэсэн заалтууд оржээ. Уг гэрээг байгуулснаар Англи улс Энэтхэг дэх өөрийн ашиг сонирхлыг давхар баталгаажуулсан бөгөөд ялангуяа дэлхийн 1-р дайны үед Энэтхэг рүү халдах довтолгооноос урьдчилан сэргийлж чаджээ.⁶

1904 онд Янгхасбэнд Лхас руу цэрэг командлан довтолоход Далай лам тэндээс Монгол руу зугтаж, Өргөөнд иржээ. Манжийн хаан Далай ламыг хаан ширээнээс нь огцруулах зарлиг буулгасан ч ямар нэг нөлөө болсонгүй. Сүсэгтнүүдийн дургүйцлээс эмээж удалгүй Манжийн хаан энэ бодлогоосоо татгалзав. Монголоос гараад Далай лам Хятадын Ганьсү мужийн Сининд очиж, улмаар 1908 онд Бээжинд Манж Чин улсын хаантай уулзав. Түүхчид Манжийн хаан Далай ламыг бие даасан тусгаар улсын тэргүүн лүгээ уулзаж буй мэт

хүлээн авсан гэж тэмдэглэсэн байдаг. Ингэсээр 1909 оны 12 сард тэрбээр Лхаст эгэн очсон байна. Энэ үед зүүн Төвдөд Чин улсын цэргүүд түрэмгийлэн харгислаж байлаа. Далай лам энэ байдлыг зогсоохын тулд Бээжин дэх Англи, Франц, Орос болон Японы Элчин сайдын яамдаар дамжуулан тусламж хүссэн захидал илгээсэн ч нааштай хариулт авсангүй. Гол нь Төвдөөс хятад цэргүүдийг гаргахыг хүссэн байна.

Удалгүй 1910 оны 2 сарын 12-нд 2000 гаран хятад цэргээс бүрдсэн Чингийн арми Лхас руу хэрцгийлэн халдав. Тэд энгийн номхон иргэдийн аминд хүрч, Төвдийн зарим сайдуудыг нь баривчлав. Далай ламыг мөн баривчлах нь тодорхой болмогц Далай лам зарим сайд, түшмэд, 200 гаран цэргийн хамт Энэтхэг рүү даван зугтжээ. Ингэхдээ төрийн тамгаа авч явсан байна. Хэдийгээр хятад цэргүүд салахгүй нэхэж байсан ч төвд цэргүүд амь хайргүй тулалдан тархан зугтах маягаар хуурч Далай лам бараа бологчдын хамт арай чамай амь гарчээ. Лхасаас гараад 9 өдрийн дараа Сиккимийн хил давж аюулаас зайлж чадсан ажгуу.

Улмаар Далай лам зарим сайд, түшмэд бараа бологчдын хамт Даржаалинд 2 жил гаран дүрвэн суужээ. Энэ үедээ голлон Английн Засгийн газарт хандаж Төвд орныг чөлөөлж өгөх, хамгаалалдаа авахыг гуйсан хүсэлт удаа дараа тавьсан ч Англи үүнийг нь хүлээн авсангүй, дараа нь Оросын хаанд хандан өмгөөлөлдөө авахыг хүссэн ч нааштай үр дүн гарсангүй. Ингэж байтал Дундад иргэн улсын ерөнхийлөгч болсон Юань Шикай Төвдийг өөрийн нэг муж гэж зарласан нь өмнөх автономит статусыг нь ч уландаа гишгэсэн хэрэг байлаа.

Гэтэл энэ үед Монгол улс тусгаар тогтнолоо зарласан байсан агаад 1912 онд Монгол-Оросын гэрээ байгуулагдав. Ийм түүхэн цаг нөхцөл байдлын дунд Төвд- Монголын гэрээ байгуулагдах үндэс суурь тавигдсан билээ. Ингээд 1913 оны 1 сарын 11 –нд Монгол- Төвдийн гэрээ байгуулагдсан юм.

Симла-гийн Бага хурал

Төвдийн түүхэнд нэлээд чухал үүрэг гүйцэтгэж түүхэнд нь тэмдэглэгдэн үлдсэн энэ бага хурлаар Төвд, Англи, Хятад гурван улсын гэрээг байгуулсан юм. Төвдийн талыг төлөөлж Лөн Чэн Шатра, Английг Сэр Хэнри Мэк Махон, Хятадыг Чэн (И Ван Чэн ч гэж нэрлэдэг) нар тус тус төлөөлөн оролцсон бөгөөд 1913 оны 10-р сард эхэлж тохиролцохгүй удаашран 6 сар сунжирсан энэ хэлэлцээрийн дүнд 1914 оны 4 сарын 27-нд Convention буюу Гэрээ байгуулсан юм. Энэхүү Симла-д болсон Бага хурлаар Төвдийн асуудал, ялангуяа уг орны эрхзүйн бүхий л тулгамдсан асуудлыг өргөн хүрээнд хэлэлцсэн ажгуу.⁷

Симла-гийн гурван улсын хэлэлцээрийн гол гол заалтыг албан бусаар орчуулан толилуулбал дараах мэт:

1. Төвд улс нь Гадаад Төвд, Өвөр буюу дотоод Төвд гэж хоёр бүсд хуваагдана. Эхний бүс нь Энэтхэгт ойрхон хэсэг ба Лхас, Шигацэ, Чамдо-г багтаана. Удаах хэсэг нь Хятадад ойрхон хэсэг ба Батанг, Литанг, Тачиенлу болон Зүүн Төвдийн нэлээд хэсэг багтана.
2. Нийт Төвд нутаг Хятадын сюзерн болохыг хүлээн зөвшөөрөв. Гэвч Хятад улс Төвдийг Хятадын нэгэн муж болгохгүй.
3. Их Британи улс Төвдийн аль нэг хэсгийг өөрийн болгохгүй.
4. Гадаад Төвдийн автономийг хүлээн зөвшөөрнө. Хятад улс Төвдийн засаг захиргаанд нь оролцохгүй, уг эрх нь төвдчүүдэд өөрсдөд нь

харъяалагдана. Хятад улс мөн Төвд рүү цэрэг илгээх, иргэд хийгээд цэрэг байрлуулах, тэнд Хятадын колони байгуулахаас татгалзана. Британи нь нийт Төвд даяар эдгээр үйлдлийг хийхээс зайлсхийнэ. Харин худалдааны агентууд байрлана.

5. Дотоод буюу Өвөр Төвдэд Төвдийн Төв Засгийн газар одоо эдэлж буй эрхүүдээ үргэлжлүүлэн эдлэх ба тэдгээрийн дотор ихэнх сүм хийдийг хянах, орон нутгийн тэргүүнүүдийг томилох эрхээ эдэлнэ. Харин Хятадын талаас цэрэг, түшмэл илгээх, тэнд колонио байгуулахыг хориглохгүй.
6. Лхаст 300 хүнээр хязгаарласан цэргийн бараа бологч бүхий Хятадын Амбаны газрыг дахин байгуулна.
7. Британий худалдааны агентуудын бараа бологчид нь Хятадын бараа бологчдын тооны 4-ний 3-аас хэтрэхгүй.
8. Гянци дэх Британий агент Гянци-д шийдвэрлэж боломжгүй хэргээр Лхаст зорчих эрх эдэлнэ.

Дээрх гэрээ нь нийт ийм найман зүйлтэй. Уг гэрээгээр 1893, 1908 онуудын худалдааны журмыг халсан байна. Харин Энэтхэг, Гадаад Төвдийн хоорондын худалдааны зохицуулах журмыг баталжээ. Гэтэл гэрээ байгуулагдаад удаагүй байтал Хятадын тал өөрийн бүрэн эрхт төлөөлөгчөө уг гэрээг батламжлах эрх байгаагүй гэсэн шалтаг заан гэрээнээс хойш суух, гарах арга сүвэгчилж эхлэв. Тэгж байгаад удалгүй өөрийн төлөөлөгчөө ч татав. Энэ гэрээ нь гол субъект болох Төвдийн талд амаргүй даваа байсан нь ойлгомжтой. Гэтэл удалгүй дэлхийн 1-р дайн дэгдэж Англи улс юун Төвдтэй манатай болов. Гэхдээ Симла-гийн гэрээ нь Төвд болон Хятадын хилийг харилцан хүлээн зөвшөөрсөн гэрээ байсан гэж үзэх бүрэн үндэстэй. Энд заавал дурдах ёстой зүйл бий.

Төвд-Хятадын хилийн гэрээг 1727 онд албан ёсоор байгуулж, батламжилсан байдаг. Гэтэл мөн онд Орос, Чин улс хоёр Буурын болоод Хиагтын гэрээгээр өнөөгийн Монгол, Орос хоёр орны хилийг тогтоосон байдаг. Эндээс үзэхүл 1727 онд Манж Чин улс хилийн томоохон дипломат ажиллагаа явуулсан нь тодорхой байна. Түүнчлэн Монголыг Ар, Өвөр болгон хуваасан дипломат операци Төвдөд давтагдсан байх юм. Симла-гийн гурван улсын хэлэлцээр ч Хиагтын гурван этгээдийн хэлэлцээр лүгээ төстэй байдлууд ч байгаа юм.

Монгол-Төвдийн гэрээ байгуулагдах урьдчилсан нөхцөл бүрдсэн нь

Чин улс мөхсөнөөр ноёрхолд нь байсан улс үндэстнүүдийн өмнө тусгаар тогтнох зам нээгдсэн билээ. Монгол болон Төвдийн өмнө ч ийм зам нээгдсэн. Гэтэл тусгаар тогнолынхоо төлөө эрс тэмцэж байсан Монгол, Төвдийн эсрэг Бээжингийн зүгээс янз бүрийн бодлого явуулж эхлэв. Тухайлбал, 1912 онд “Монгол Төвдийг нэгтгэх хурал” гэгч байгууллагыг байгуулав⁸. Уг хурал гэгчээс 1912 онд Монгол улсын Засгийн газарт цахилгаан утас ирүүлж, түүндээ: “Эдүгээ Манж, Монгол, Хятад, Хотон, Баруун зуу (Төвд) таван төрөл бүгдээр нэгэн гэр бүл болсонд бүх улс үл баярлах нь үгүй” гэхчилэн ятгаж байв.⁹

Дундад Иргэн улс Бээжин дэх зарим монгол ноёд лам нарын саналын дагуу 1912 онд Монгол Төвдийн хэргийн товчоо (Мен-Зан Шиүжюй) гэгчийг Гадаад Монголын төрийг засах явдлын яамны оронд байгуулж, харчин жүн ван Гүнсэnnоровоор толгойлуулжээ. Тэрбээр яваандаа Юань Ши Кайн гар хөл болон

хувирсан ажгуу.¹⁰ Ингэж байгаад, өөрөөр хэлбэл бэлтгэлээ базаасны дараа Дундад Иргэн улсын “Улсын хурал”-ыг хуралдуулж уг хурлаар 1912 оны 3 сард ДИУ-ын Түр Үндсэн хуулийн баталжээ. Уг Түр Үндсэн хуулийн 3-р зүйлд : “Дундад Иргэн улсын нутаг дэвсгэр нь 22 муж, Ар, Өвөр Монгол, Төвд, Хөх нуураас бүрдэнэ” гээд мөн 18-р зүйлд “Муж, Ар, Өвөр Монгол, Төвд нь тус бүр таван төлөөлөгчийг Үндэсний хуралд сонгоно.” гэсэн заалт оруулсан байна.¹¹ Ийм эгзэгтэй байдлын дунд Монгол, Төвд хоёр орон харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулсан юм.

Монгол-Төвдийн гэрээний монгол хэлээр буй эх

Үндэсний түүхийн архивт уг гэрээний эх нь хадгалагдаж байна. А-4, 1. ХН-135-д буй гэрээг кирилл үсгээр сийрүүлбэл дараах мэт:

Монголын Олны Өргөгдсөний хоёрдугаар он, арван хоёр сарын хорин еснөө Нийслэл Хүрэнээ хэлэлцсэн Гэрээ бичиг

Монгол Төвд тус бүр Манж Хятадын эрх мэдлээс ангижран, тусгаар байгуулсан бөгөөд, язгуураас шашин шүтлэгийн хэлхээ холбоо нэгэн болохын учир Үүнээс хоёр улс харилцан бие биес дор тус бололцох тухайг өөр өөрийн Засгийн газрын заавраар Найрамдлын Гэрээ хэлэлцэх тухай.

Богд хааны зарлигаар томилогдсон Гадаад Яамны сайд нягт билигт Да лам Равдан, эрхэлсэн түшмэл жанжин Манлай баатар бэйс Дамдинсүрэн, Төвдийн хаан Далай ламын зарлигаар томилогдсон Гүжир Цансив Ханжин, Луузан Агваан, донир Агваанчойнжин, Мөнгөн сангийн тэргүүлэгч Ишжамц, бичээч Хандгалсан нар хэлэлцэн тогтоосон ану:

1. Төвд улсын эзэн Далай ламаас Монгол улсын тусгаар байгуулагдсаныг зөвшөөрөн хүлээснээс гадна, Монгол улсын шарын шашны эзэн Жавзандамба ламыг гахай жилийн гахай сарын есөнд Монголын хаан болгож өргөмжилснийг басхүү зөвшөөрөн хүлээвэй.

2. Монгол улсын эзэн Жавзандамба лам Төвдийн тусгаар байгуулагдсаныг зөвшөөрөн хүлээснээс гадна Төвд улсын хаанд Далай ламыг өргөмжилснийг басхүү зөвшөөрөн хүлээвэй.

3. Монгол, Төвд хоёр улс үүнээс хойш Буддын шашныг хэзээд бадраан дэлгэрүүлсээр байхыг хичээх хэрэгтэй.

4. Хоёр этгээд эдүгээгээс гадаад дотоодын харшлах дайсанд тохиолдох аваас хэзээд харилцан хамгаалж тусламуй.

5. Хоёр улсаас албан, амийн ба шашин шүтлэгийн буюу ямарваа хэргээр явагчдыг харилцан туслалцмуй.

6. Хоёр улсын харилцан худалдаа нэвтрүүлэх зэргэд үл саатуулахаас гадна, мөн эд боловсруулах газар байгуулавч болно.

7. Хоёр улсын харъяат нар харилцан мөнгө хүүлэх хэрэг буй аваас эрхбиш өөр өөрийн Засгийн газраа мэдүүлж гүйцэтгэх хэрэгтэй. Хэрэв тэр ёсоор эс үйлдвээс аль ч албаны газар авч хэрэгсэхгүй. Хэрвээ үүнээс урьдаар гарсан хэрэг бөгөөд, нэгэн этгээд хэтэрхий хохирсон зүйл буй аваас аль ч газар албан болгон авч хэлэлцмуй. Бүх хошуу шавийн дунд авсан ану бус болвоос зөвхөн авсан этгээдээс төлүүлвээс зохимуй.

8. Эдгээр зүйлд нэмэн хэлэлцэх хэрэг буй аваас хоёр улсын Засгийн

газраас тусгай төлөөлөгч нарыг томилон гаргаж хянан хэлэлцүүлж нэмэн тогтоолговоос болмуй.

9. Энэхүү Гэрээг хоёр этгээд гар талбисан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болмуй.”

Энэхүү гэрээг “Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл”. 189-190-р талд мөн хэвлэсэн байдаг.¹²

Харин Үндэсний архивын А-4, ХН-9-д ерөнхийдөө адилхан ч бага зэрэг өөр найруулгатай эх хадгалагдаж байна. Гэрээг батламжилсан хүмүүсийн гарын үсэг, тэмдэг бүхий уг эхээс сийрүүлбэл:

“Нийслэл Хүрээний сонин соногсол.

Харбин хотын сонин бичгийн Хорооноо өргөн хүргүүлэх ажсаамуу.” гэж эхэлжээ. Эндээс үзэхүл Харбинд байрлаж байсан “Нийслэл Хүрээний сонин бичиг”-т эл эхийг илгээсэн юм уу, илгээхээр зэхсэн болж таарч байна.

Улмаар эхний эх бичгээс ялимгүй өөр байгаа нь :

“Бидний Монгол Төвд хоёр улс Чин улсын мэдлээс гарч, Хятадаас салаад, тус бүр өөртөө эзэрхэх улс төр байгуулсан ану” гэхчилэн үргэлжлэх агаад сонирхолтой нь уг гэрээний үг хэллэг найруулгаас үзэхэд “Чин улсын мэдлээс гарч, Хятадаас салсан” хэмээн Чин улс болоод Хятадын аль алинд нь Монгол, Төвд хоёр улс цаашид харъяалагдахгүй болсныг тодорхой илэрхийлжээ.

Түүхч Б. Лхамсүрэн энэхүү гэрээг байгуулах болсон шалтгааныг дараах маягаар үзжээ.

“Богдын Засгийн газар Манж Хятадаас туурга тусгаар өөрийн эзэн хаант Монгол улс байгуулсныг шашин нэгт ертөнцөд тунхаглаж, сүсэгтэн олны өргөн дэмжлэг олохыг чухалчилж байсан бөгөөд 1913 оны 1-р сард Нийслэл хүрээнд Монгол, Төвдийн хооронд Найрамдлын гэрээ байгуулсан нь энэ зорилгод бүрэн нийцжээ.”¹³

Монгол-Төвдийн гэрээний англи эх:

TREATY OF FRIENDSHIP AND ALLIANCE

Concluded Between the Government of Mongolia and Tibet at Urga

29 December 1912 (11 January 1913)

(translation of the Tibetan text)

Mongolia and Thibet, having freed themselves from the dynasty of the Manchus and separated from China, have formed their pwn independent States, and, having in view that both States from time immemorial have professed one and the same religion, with a view to strengthening their historic and mutual friendship the Minister for Foreign Affairs, Niikta Biliktu Da-Lama Rabdan, and the Assistant Minister, General and Manlai Baatyr beiseh Damdinsuren, as plenipotentiaries of the Government of the ruler of the Mongol people, and gudgir tsanshib kanchen-Lubsan-Avgan, donir Agvan Choinzin, director of the Bank Ishichjamtso, and the clerk Gendun Galsan, as plenipotentiaries of the Dalai Lama, the ruler of Thibet , have made the following agreement.

Article 1. The ruler of thiber nad, Dalai Lama, approves and recognazes the formation of an independent Mongol State, and the proclamation in the year of the pig and the ninth day of the eleventh month, of Chjebzun Damba Lama of the yellow faith as ruler of the country.

Article 2. the ruler of the Mongol people, Chjebzun Damba Lama, approves and recognazes the formation of an indepemdent (Thibeten) State and the Dalai Lama as ruler of Thibet.

Article 3. Both States will work by joint consideration for the well-being of hte Buddhist faith.

Article 4. Both States, Mongolia and Thibet, as formerly, from now and for all time will afford eavh other assistance against external and internal dangers.

Article 5. Each State whithin its own territory will afford assitance to the subjects of the other travelling officially or privately on affairs of religion or States

Article 6. Both States, Mongolia and Thibet, as formerly, will carry on a reciprocal trade in the products of their respective countries in wares, cattles and c., and will also open industrial establishments.

Article 7. From now the granting of credit to anyone will be permitted only with the knowledge and sanction of official institutions. Without such sanction Government institutions will not consider claims.

As regards contracts made previous to the conclusion of the present treaty, where serious loss is being incurred through the inability of the two parties to come to terms, such debts may be recovered by /Governement/ institutions, but in no case shall the debt concern "shabinars" "khoshuns".

Article 8. Should it prove necessary to supplement the articles of the present treaty, the Mongolian and Thibetan Givernemtns must appoint special delegates, who will conclude such agreements as the conditions of the time shall demand.

Article 9. The present treaty shall come into force from the date of its signature.

Plenipotentiaries from the Mongolian Government for the conclusion of the treaty: Nikta Biliktu Da Lama Rabdan, Minister for Foreign Affairs; and General and Manlai baatyr beiseh Damdinsurun, Assistant Minister.

Plenipotentiaries from the Dalai Lama, the ruler of Thibet , for the conclusion of the treaty: Gudjir tsanshib kanchen Lubsan- Agvan, Choinzin, the Director of the Bank of Thibet Ishichjamtsa, and the clerk, Gendun- Glasan.

Signed /by Mongol reckoning/ in the fourth day of the twelfth month of the second year of the "Raised by the Mnay", and by Thibetan reckoning on the same day and month of the year of the "water-mouse."¹⁴

Монгол-Төвдийн гэрээний дараа

Уг гэрээ нь Төвдөд ихээхэн ач холбогдолтой байсан гэж хилийн чанад дахь төвдчүүд, гадаадын эрдэмтэд үздэг. Учир нь одоо ч гэсэн Төвдийн тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийн болоод дэмжигчдээс хилийн чанадад хэвлүүлсэн эмхтгэл, эрхзүйн баримт бичгүүд, вэб сайтуудад эл гэрээний англи орчуулга ямагт орсон байдаг юм. Төвд орчин үеийн түүхэндээ цөөхөн оронтой харилцаж байсан тул байгуулсан гэрээ нь төдийлөн олонгүй.

Харин Төвдийн хувь заяаны талаар төвд хүний өөрийнх нь үнэлж дүгнэж бичсэн нь бидэнд сонирхолтой агаад сургамжтай болов уу гэж бодож байна. Даваа Норов хэмээх Төвдийн сэхээтэн 1974 онд "Red Star Over Tibet" хэмээх бүтээл туурвисан нь олонд түгжээ.¹⁵ Энэ номондоо тэрбээр өөрийн намтраас гадна Төвдийн түүх, зан заншил, ойрхи үед болсон үйл явдлуудыг нэлээд тодорхой өгүүлсэн байдаг.

“1910 онд манж нар Төвд рүү цэрэг хөдөлгөн довтлоход Далай лам Энэтхэг рүү дутаасан юм. Гэтэл 1911 онд Хятадад цагаагчин гахай жилийн хувьсгал дэгдмэгц 1912 онд төвдүүд хятадуудыг эх нутгаасаа хөөн гаргасан болой. Ингэснээр Төвд улс бүрэн тусгаар тогтносон улс болж 1912 оноос 1950 онд Хятадууд халдан ирэх хүртэл Хятад ч тэр, өөр гүрэн ч тэр Төвдөд байгаагүй юм хэмээн Далай лам бичсэн буй... Олон улсын Шүүгчдийн Хороо (International Commission of Jurists) НҮБ-д өргөн барьсан “Төвдийн асуудал ба хуулийн засаглал” хэмээх илтгэлд ийнхүү дүгнэсэн байдаг: ...38 жил Төвд де факто тусгаар тогтнолтой улс байсан.

Тиймээс Хятад Японы дайнд ороогүй, Дэлхийн 2-р дайны үед Энэтхэгээс Хятад руу дайны ханган нийлүүлэх ажил хийхэд газар нутгаараа тэвэрлүүлэхээс татгалзаж байлаа. Мөн Делид болсон Азийн орнуудын Бага хуралд төлөөлөгчөө оролцуулж байсан юм.

1948 онд Төвдийн паспортыг Энэтхэг, Хятад, Франц, Итали, Их Британи, АНУ хүлээн зөвшөөрсөн байсан бөгөөд ийм паспорттойгоор гадаадад худалдааны төлөөлөгчөө илгээж байлаа. Эдгээр баримт нь Төвдүүд эцсийн хормыг хүртэл тусгаар тогтнолоо баталгаажуулах боломж эрж байсныг харуулна.”

Даваа Норов Төвд орон тусгаар тогтнолоо алдсан шалтгааныг дараах байдлаар авч үзсэн:

1. Лам нарын фанатик үзэл, харанхуй бүдүүлэг байдал
2. Язгууртнуудын хариуцлагагүй, бас зугаа цэнгэлд дуртай араншин
3. Төвдчүүдийн туйлын эгэл бүдүүлэг байдал, гэнэн шинж ”

“Хамгийн гол нь язгууртнууд, төрийн түшмэд Төвдийн тусгаар тогтнолыг алдахад гол үүрэг гүйцэтгэсэн. Үүргээ үл ухамсарладаг, улс төрийн талцаанд оромтгой, тансаглах дуртай...1950 онд хятадууд Амдо руу довтлон тэндхийн гарнизоныг эзлэхэд Лхас руу яаралтай буухиа элч илгээсэн байна. Элчийг довтлогосоор ирэхэд Засгийн газрын түшмэд наадгай тоглоод сууж байсан бөгөөд тоглож дуустлаа элчийг оруулаагүй гэдэг...”

“1933 онд 13-р Далай лам өөд болоход Сэра хийд болон Лхас дахь Засгийн газрын хооронд зөрчилдөөн үүссэн юм. Удалгүй тэр нь зэвсэгт мөргөлдөөн болсон ... Улмаар Рэтинг хийдийн Рэнбүүчи өөрийн хийдийг баян хүчирхэг болгох зорилгоор төрийг хутгаж эхэлсэн ба 1947 онд улс төрийн өрсөлдөгч нар нь түүнийг баривчилж тэр ч удалгүй нас эцэслэсэн...”

Тэр үед Төвдийг өөрчлөн шинэчлэх гэсэн ардчилсан залуу шинэ үеийнхэн байсан ч тэднийг баривчлан хорьж, тагнуул туршуул хэмээн гүтгэж дарсан билээ... Төвдийн асуудалд төвдчүүд бид өөрсдөө голлон буруутай. Систем нь голдоо ортлоо ялзарсан байсан учраас 20-р зууны дарамт шахалтанд тэсч чадахгүй унахад бэлэн болчихсон байсан бөгөөд уналт эхэлмэгц сүйрэн унасан” гэсэн байна.

Ном зүй

1. Behr, W. *Oriens* 34. 1994. 557-564.
2. *Tibet Past and Present*, by Sir Charles Bell. Oxford, At the Glarendon Press. 1969, p-13.
3. Rockhill. *Ethnology of Tibet*. 669.
4. Д. Б. Улымжиев, А. В. Дамдинов. "Международные отношения вокруг Тибета в конце XIX-начале XX в. и дипломатическая деятельность Агвана Доржиева", В книге "Монголоведные исследования" Улан-Удэ в 1997. стр-62.
5. *The Dalai Lamas of Lhasa*. By W.W. Rockhill. *Toung Pao*. Series III. Vol.1. number 1. pp.37-42.
6. Sir Charles Bell. p-90.
7. Sir Charles Bell-ийн ном. 154-р тал.
8. Хэрээд Л. Жамсран. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. УБ: 1997. 45-р талд.
9. Л. Дэндэв. "Монголын товч түүх", УБ. 1934. 33-р тал
10. Л. Жамсран. Мөн тэнд. 46-р талд.
11. Л. Жамсран. 4-р талаас тодруулан үзнэ үү.
12. Баримт бичгийн эмхтгэл. (1900-1914), УБ. 1982.
13. Б. Лхамсүрэн. Монголын гадаад орчин төрийн тусгаар тогтнол. УБ. 1995. 15-р талд.
14. Source: FO 535/16, No.88, Inclosure1, 1913. Reproduced from M.C. Van Walt van Praag's *Status of Tibet: History, Rights and Prospects in International Law*.
15. Collins St. James's Place, London. 1974.

Төвдийн талаар цаашид гүнзгийрүүлэн уншъя гэвэл:

1. Dowman, Keith (1988). *The Power-Places of Central Tibet: The Pilgrim's Guide*. Routledge & Kegan Paul. London, New York.
2. Shakya, Tsering (1999). *The Dragon in the Land of Snows: A History of Modern Tibet Since 1947*. Columbia University Press.
3. Pachen, Anj; Donnelly, Adelaide (2000). *Sorrow Mountain: The Journey of Warrior Nun*. Kodansha America Inc.
4. Goldstein, Melvyn C., with the help of Gelek Rimpoche. *A History of Modern Tibet, 1913-1951: The Demise of the Lamaist State*. Munshiram Manoharlal Publishers (1993), University of California (1991).
5. Grunfield, Tom (1996). *The Making of Modern Tibet*.
6. Norby, Thubden Jigme; Turnbull, Colin (1968). *Tibet: Its History, Religion and People*. Reprint: Penguin Books (1987)
7. Stein, R. A. (1962). *Tibetan Civilization*. First published in French; English translation by J.E. Stapelton Driver. Reprint: Stanford University Press, 1995.